

СИСТЕМ ХЭРЭГЛЭГЧДИЙН АНХААРАЛД

“Худалдан авах ажиллагааны цахим систем”-ийн сервер компьютерт 2019 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 15:30-д техникийн гэмтэл гарсан бөгөөд 2019 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 23 цаг хүртэл цахим системийн үйл ажиллагааг зогсоож, гэмтэлийг арилгаж, тоног төхөөрөмжийг шинэчлэн, сервер компьютерийн тохиргоо болон бусад шаардлагатай туршилт, тохируулгыг хийж гүйцэтгэлээ.

Сангийн сайдын 2013 оны 01 сарын 11-ний өдрийн 7 тоот тушаалаар батлагдсан Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын 10 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “Давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас цахим систем ажиллах боломжгүйгээс шалтгаалан тендерт оролцогч тендерт оролцох боломжгүй болсон тохиолдлоос үүдэн гарах аливаа хариуцлагыг захиалагч хариуцахгүй”, 10 дугаар зүйлийн 3-т “10.2-т заасны дагуу цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд тендерийн нээлтийг тодорхой хугацаагаар хойшлуулж санал ирүүлсэн бүх тендерт оролцогчид энэ тухай нэгэн зэрэг албан бичгээр мэдэгдэнэ.” гэж заасныг үндэслэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас дараах арга хэмжээг авч байна. Үүнд:

- 2019 оны 01 сарын 17-ны өдрийн 15 цаг 30 минутаас хойшоо буюу тендерийн нээлт хийж амжаагүй 2 тендерийн урилгыг 2019 оны 01 сарын 21-ний өдрөөр;
- 2019 оны 01 сарын 18-ны өдөр тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусч, тендерийн нээлт хийгдэх байсан 30-н тендерийн урилгыг 2019 оны 01 сарын 21-ний өдрөөр;
- Тендерт оролцохыг сонирхогч этгээдээс тендерийн баталгаа гаргах зэрэг тендерийн материал илгээх боломжит хугацаа олгох зорилгоор 2019 оны 01 сарын 21-ний өдөр нээлт хийх 49-н тендерийн урилгын тендер хүлээж авах эцсийн хугацааг 01 сарын 21-ний өдөртөө багтаан сунгах;

Нийлүүлэгч байгууллага нь дээрх мэдэгдлийн дагуу хойшлуулсан нээлтийн хугацаанд өөрийн байгууллагын тендерийн баталгаа, тендерийн баримт бичгийг дахин хянан үзэж тендерт оролцоно уу.

Шаардлагатай тохиолдолд тус газрын Мэдээлэл технологийн албаны it@procurement.gov.mn имэйл болон <https://helpdesk.tender.gov.mn> системээр дамжуулан бидэнтэй холбогдоно уу.

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР
МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН АЛБА